



БНМАУ
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

19 91 оны 5 сарын 08

№ 129

Улаанбаатар
хот

Туслах аж ахуй байгуулж ажил-
луулах тухай

Улс орон зах зээлийн харилцаанд шилжиж байгаа өнөөгийн нөх-
цөлд аппаратын ажилчин албан хаагчдын болон цайны газарт шаар-
дагдах мах, сүүний хэрэгцээний зарим хэсгийг бие даан хангах
шаардлагатай байгааг тэмдэглэж ТОГТООХ нь:

Хэрэг эрхлэх газар /Ч.Сумаахүү/-т зөвшөөрөх нь:

1.Туслах аж ахуйд мал, хашаа байр худалдан авахад зориулж
300 мянган төгрөгийг төсвийн гадуурх хөрөнгөөс гаргах.

2.Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанд Зоч-
ны үйлчилгээнд зориулан ашиглагдаж байсан Чайк маркийн суудлын
авто машиныг худалдаж үнийг мал, хашаа байр худалдан авах хөрөн-
гийн эх үүсвэрт зарцуулах.

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-
ГААНЫ ДАРГА

Л.ЭНЭБИШ

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Ч.СУМААХҮҮ